



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: (976-51) 26 23 50,
Цахим шуудан: info@pcsp.gov.mn,
Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2025. 02. 07 № 87/248
таний -ны № -т

ТӨРИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД

Г Мэдээ, тайлан ирүүлэх тухай

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 07 дугаар тушаалаар “Төрийн болон Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-ийг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөг баталж 9 дүгээр сараас эхлэн Монгол Улсын нийт иргэдэд нээлттэй болгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна.


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 07 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөнд төрийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд хийхээр тусгасан ажлын төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлж байна.

Иймд хөрөнгийн 2024 оны болон 2025 оны эхний хагас жилийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, тайлан мэдээг шилжилтийн цахим системд оруулах ажлыг <https://pcsp.gov.mn/> цахим хуудсанд болон програмд байршуулсан видео хичээлтэй танилцаж, үнэн зөв, бүрэн хийх ажлыг 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор багтаан зохион байгуулахыг мэдэгдье.

Дээрх ажлын хүрээнд бий болсон мэдээллийн санг шинээр нэвтрэх цахим системд суурь мэдээлэл болгон ашиглах тул тайлан мэдээ хулээн авах талаарх цахим сургалтад хамрагдаж, мэдээллийн дүүргэлтийн чанар байдлыг сайжруулж, тайлан мэдээг цаг хугацаанд нь багтаан оруулах, явцын хяналт тавих ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах хэрэгтэй.

Бид батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалтын контент, цахим болон танхимиын сургалтыг үе шаттай зохион байгуулах бөгөөд энэ талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудас болон програм хангамжид тухай бүр нь мэдээллэх ажлыг зохион байгуулах болно.

Хавсралт хуудастай



Б.ЦЭНГЭЛ

• 132000417

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2025 оны 01-дугаар сарын 01-ны өдрийн

A-1/278 дугаар албан бичтийн хавсралт

**ШИНЭ ЦАХИМ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХЭД ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ХИЙХЭЭР ТУСГАСАН
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах этгээд
Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээдийн хувьд:			
1	Шилжилтийн системийг ашиглах сургалтыг Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээдэд зохион байгуулах	2-р сарын 14-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Төрийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
2	Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээдүүд хөрөнгийн хөдөлгөөний мэдээллээ шилжилтийн системд оруулж эхлэх	1-р сарын 31-ний өдрөөс 4-р сарын 20-ны өдрийг хүртэл	ТӨБЗГ, Төрийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
3	Барилга, байгууламжийн бүртгэлийг барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн бүртгэл гэж 3 салгах, мэдээллийг бүрэн оруулах нягтлах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Төрийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
4	Газрын бүртгэлийг E-Gazar цахим системтэй тулгах мэдээллийг бүрэн оруулах нэгж талбарын дугаарыг нягтлах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Төрийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
5	Тээврийн хэрэгслийн бүртгэлийг VRS-Transder цахим системтэй тулгах мэдээллийг бүрэн оруулах Улсын дугаар, Арлын дугаарыг нягтлах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Төрийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
6	Машин тоног төхөөрөмжийн бүртгэлийг МТТ (үйлдвэрлэл, тусгай зарцуулалтын тоног төхөөрөмж), Оффисын жижиг тоног төхөөрөмж (компьютер түүний дагалдах хэрэгсэл) Батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмж гэж 3 салгах, мэдээллийг бүрэн оруулах нягтлах, багцалж нэг бүртгэсэн бүртгэл байвал задалж бүртгэх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Төрийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
7	Тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэлээс Номын фондыг салгах, мэдээллийг бүрэн оруулах нягтлах, багцалж нэг бүртгэсэн бүртгэл байвал задалж бүртгэх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Төрийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
8	Бүх биет үндсэн хөрөнгийн бодит 3 хүртэлх зураг оруулах, биет бус хөрөнгийн лиценз, гэрээ, гэрчилгээ, програмын цонхны зураг зэргийг оруулах (odoogийн байдлаарх)	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Төрийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд

9	2024 оны хөрөнгийн хөдөлгөөнийг 2025 оны 4 сарын 20-ны өдрөөс өмнө, 2025 оны хөрөнгийн хөдөлгөөнийг 6 сарын 31-ний өдрөөс өмнө цахим системд оруулсан байх	2024 оны хөрөнгийн хөдөлгөөн 4-р сарын 20-ны өдрөөс өмнө, 2025 оны хөрөнгийн хөдөлгөөн 6-р сарын 31-ний өдрөөс өмнө	ТӨБЗГ, Төрийн өмчтэй (оролцоотой) бүх хуулийн этгээд
10	Нийслэл, 21 аймгийн төрийн болон орон нутгийн өмчтэй байгууллагуудад шинэ системийн сургалт зохион байгуулах	7-р сарын 01-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Төрийн өмчтэй (оролцоотой) бүх хуулийн этгээд
Төрийн болон Орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газар, компанийн хувьд:			
11	Төрийн болон Орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газар, компанийн Хувьцаа эзэмшигчийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын удирдлагын модуль бэлэн болсон байх /Шаардлагатай мэдээлэл судалгааг бэлтгэх/ /Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани
12	Төрийн болон Орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газар, компанийн судалгаа гаргах модулийн мэдээлэл бэлэн болсон байх 1. ТУЗ-ын гишүүдийн судалгаа 2. Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтны судалгаа 3. Хуулийн этгээдээс тухай бүрд нь динамик байдлаар авах судалгаа 4. Хуулийн этгээдийн хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа 5. Хэрэглэгчийн санал асуулга /Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани
13	Төрийн болон Орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газар, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалт, нөөц бүрдүүлэх модулийн мэдээлэл, шалгуур үзүүлэлт, холбогдох мэдээлэл бэлэн болсон байх. /Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани
14	Төрийн болон Орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газар, компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүний гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын тайлан, үнэлгээ, цалингийн модулийн мэдээлэл боловсруулж, системд оруулах холбогдох мэдээлэл бэлэн болсон байх. /Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани
15	Төрийн болон Орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг тайлagonах модулийн мэдээлэл бэлэн болсон байх. Санхүүгийн болон бусад аудитын тайлан, түүний дүгнэлт, зөвлөмж, акт, биелэлт. /Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани
16	Төрийн болон Орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн Зорилтын саналын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг дүгнэх модулийн мэдээлэл бэлэн болсон байх. Зорилтот түвшин, Хөрөнгө оруулалт, аудитлагдсан санхүүгийн тайлангаас автоматаар таталт хийн дүгнэдэг байх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани

	/Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/		
17	Төрийн болон Орон нутгийн өмчтэй Хуулийн этгээдийн жил бүрийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг төлөвлөх, түүний хэрэгжилтийг дүгнэх модулийн мэдээлэл бэлэн болсон байх /Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани
18	Төрийн болон Орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн жил бүрийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, түүний хэрэгжилтийг дүгнэх модулийн шалгуур үзүүлэлт мэдээлэл бэлэн болсон байх /Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани
19	Төрийн болон Орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэгтгэн дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийх модулийн мэдээлэл бэлэн болсон байх. Зорилтын санал, Зорилтот түвшин, Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, Санхүүгийн тайлангаас автоматаар таталт хийн, шинжилгээ хийдэг болсон байх. /Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани
20	Төрийн болон Орон нутгийн өмчтэй Хуулийн этгээдтэй холбоотой санхүү, эдийн засгийн болон үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл бүхий цахим, динамик товхимлын мэдээлэл бэлэн болсон байх. /Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани
21	Төрийн болон Орон нутгийн өмчтэй Хуулийн этгээдийн шинэчлэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг дүгнэх, үр дүнг нийтлэх модулийн холбогдох мэдээлэл бэлэн болсон байх /Сүүлийн 10 жилийн мэдээлэл бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани
22	Төрийн болон Орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн Файлын сангийн мэдээлэл үүсгэхэд бэлэн болсон байх. Үүнд: А. Хуулийн этгээдийн бүртгэл, үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүд Б. Хуулийн этгээдтэй холбоотой эрх бүхий дээд шатны байгууллага буюу УИХ, Засгийн газар, ИТХ, Засаг даргын шийдвэрүүд В. Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоол, тэмдэглэлийн сан Г. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, тэмдэглэлийн сан Д. Аудитлагдсан санхүүгийн тайлан болон хууль журамд заасан нийтэд мэдээлбэл зохих бүх төрлийн мэдээллийн сан. /Тухайн хуулийн этгээдийг анх байгуулагдсанаас хойших бүх мэдээллийг бэлтгэнэ/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Үйлдвэрийн газар, компани

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

